

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.05.03 №45 (45)

ҮЙЛ ЯВДАЛ

ӨНӨӨДӨР ЦЭРГИЙН ДЭЭД ЦОЛ ОЛГОНО

Цэргийн дээд цол олгох ёслолын ажиллагаа өнөөдөр Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн Их танхимд болно.

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ой буюу өнгөрөгч гуравдугаар сарын 18-нд Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга Цэргийн дээд цол хүртээх тухай зарлиг гаргасан ч цар тахлын нөхцөл байдлын улмаас цол олгох ёслолын ажиллагааг түр хойшуулаад байсан юм.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГТ

“Хошууч генерал” цолыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Бригадын генерал

Гомбожавын Ариунбуян, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, Бригадын генерал Бужийновын Амгаланбаатар, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, Бригадын генерал Очирын Энхбаяр.

“Бригадын генерал” цолыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Дагвадоржийн Ганхуяг, ЗХЖШ-ын Нэгдүгээр орлогч дарга, хурандаа Цэвэлмаагийн Жавхланбаатар, Дотоодын цэргийн штабын дарга, хурандаа Сийлээгийн Ганбат, Хил хамгаалах ерөнхий газрын Ар тал, зэвсэглэл, инженер техник эрхэлсэн дэд дарга, хурандаа Дашдондогийн Ганбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Батмөнхийн Ууганбаяр,



ЗХЖШ-ын Материал техникийн газрын дарга, хурандаа Маждагийн Мөнхбаяр, Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, хурандаа Балжидын Баатар, Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч, хурандаа Дашцэдэнгийн Баасандамба, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга, хурандаа Батсуурийн Эрдэнэбат, ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа Дамдинсүрэнгийн Дамдинцэрэн нарт тус тус хүртээхээр туссан юм.

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 5	☁️ -3
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	☁️ 23
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 26	☁️ 14

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.845.00	2.856.00
EUR 🇪🇺	3.395.00	3.500.00
CNY 🇨🇳	439.00	442.90
RUB 🇷🇺	37.00	39.60
JPY 🇯🇵	25.71	26.59
KRW 🇰🇷	2.45	2.64

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 22
2021.05.03.
/ДАВАА ГАРАГ/

ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ САРЫН ХОЁР ХАР ЦАГААГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Идээ ундаа элбэг олдono.
Наран ургах, шингэх:
05.31-20.07
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Төрөхүй
Суудал:
Огторгуй.

Аргын тооллын 5 дугаар сарын 3, Сумъяа гараг. Билгийн тооллын 22, Булаагч одтой, цагаагчин гахай өдөр. Өдрийн наран 5 цаг 31 минутад мандан, 20 цаг 07 минутад жаргана. Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр, эе эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, хараал, жатхыг буцаах, нялхсын хурим хийх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаг гаргах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд эдлэл, идээ ундаа олно.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ ШАГНАЛ ЭЗЭНДЭЭ ХҮРЭВ



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан Ерөнхийлөгчийн зарлигаар олгогдсон “Хөдөлмөрийн хүндэт медаль” болон Ерөнхийлөгчийн нэрэмжит шагналын “2020 оны шилдэг ажилтан” өргөмжлөл эзэндээ очлоо.

Өөрөөр хэлбэл, Зэвсэгт хүчний 7780 дугаар ангийн Хиймэл байгууламжийн хэсгийн Хийц бэлтгэх бүлгийн мужаан Б.Мөнхжаргал Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын үндэсний бүтээн байгуулалтыг бусад нөхдийн хамт гүйцэтгээд

завгүй байсан тул шагналыг нь хүртээж амжаагүй байсан юм. Шагналыг ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг гардуулаад “Залуу үеийг ажил хөдөлмөр, бүтээлч үйлдвэрлэл, шинжлэх ухаанч хөгжилд уриалж, ажиллаж буй салбартаа үлгэр жишээ хувь нэмэр оруулж байгаа танд ЗХЖШ-ын даргын зөвлөлийн нэрийн өмнөөс баяр хүргэж, ажлын амжилт хүсье” гэсэн юм. Өргөмжлөлийн эзэн Б.Мөнхжаргал нь төмөр замын бүтээн байгуулалтын ажилд эхэлсэн цагаас нь хойш гар бие оролцож, хөдөлмөр бүтээлээ зориулан ажиллаж байгаа ажилтан юм.

ЗУНЫ ХУВЦАСНЫ ХАНГАЛТЫГ ЯВУУЛЛАА

Цар тахлын халдварын нөхцөл байдлаас улбаалж ЗХЖШ-ын Материал техникийн газрын даргын тушаалаар Зэвсэгт хүчний нийт гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын зуны дүрэмт хувцасны хангалтыг Зэвсэгт хүчний 310 дугаар анги дангаар хариуцан ажиллаж байна.



Тус ажлын хүрээнд ангийн бүрэлдэхүүн дөрвөн багт хуваагдан Зэвсэгт хүчний ангиудад хүрч, хангалтыг зохион байгуулаад дуусах шатандаа оржээ. Энэ тухай Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн хувцасны хангалтын тасгийн чанар шалгагч,

ахмад А.Мөнгөншагай хэлэхдээ “ЗХЖШ-ын даргын тушаалын дагуу гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид 5 дугаар сарын 1-нээс зуны дүрэмт хувцсанд шилжинэ. Үүнтэй холбогдуулан ангиуд, тэдгээр бүрэлдэхүүний хангалтыг ерөнхийд нь бүрэн хийж дуусгаад байна. Өмнө нь хувцасны нярав, бусад

албан тушаалтан өөрсдөө ирж, хувцасны хангалтаа авдаг байсан бол цар тахлын халдвар, хорио цээрийн дэглэмээс шалтгаалж энэ жил манай анги ийнхүү хангалтыг хариуцан, амжилттай зохион байгууллаа” гэв.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 38.285+1185	ЭДГЭРСЭН 21.707	НАС БАРСАН 117/9
НИЙТ БАТЛАГДСАН 2037 (24)	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ 299	ЭДГЭРСЭН 1714

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 150,989,419
Эдгэрсэн Нийт: 124,078,246
Нас барсан Нийт: 3,173,576

ТАНДАЛТ	
ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 82,683 1,296,538
ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭ /ПГУ/ СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 8,522 2,719,337
ХУРДАВЧИЛСАН ОНОШИЛГОО СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 1,201 383,925
ТУСГААРЛАЛТАД БАЙГАА ХҮН СҮҮЛИЙН 24 ЦАГТ	НИЙТ 661 68,798

2021.05.02 11:00 ЦАГНИЙ БАЙДАЛ



ТОРГОН ЦЭРГИЙН АНГИД АЛБА ХААСАН ДАЙЧДЫГ БЭЛТГЭЛЭЭР ХАЛЛАА



Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн 2020 оны нэгдүгээр ээлжээр хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчдыг бэлтгэлээр халах, Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагаа энэ сарын 30-нд боллоо. Энэхүү ёслолын ажиллагаанд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын даргын орлогч, хурандаа Д.Дугаррагчаа оролцож, бэлтгэлээр халагдаж байгаа дайчдад баяр хүргэж, цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилт хүссэн юм. Монгол Улсын Үндсэн хуулийн журамт үүргээ биелүүлж, цэргийн жинхэнэ албыг нэр төртэй хаасан түрүүч, байлдагч нарт хандаж тус ангийн захирагч, хурандаа Ж.Мөнхбаяр хэлсэн үгэндээ “Монгол Улсын иргэн бүр эх орноо батлан хамгаалах, аюулгүй байдлыг сахин хамгаалах эрхэм үүрэгтэй билээ. Та бүхэн 97 жилийн дайчин

замнал түүхтэй төрийн торгон цэргийн ангид алба хаах чин хүсэл эрмэлзэлдээ хөтөлгөдөн ирсэн цаг хугацаа саяхан мэт санагдаж байна. Эх орондоо өргөсөн тангарагтаа үнэнч байж, эр цэргийн албанд шамдан боловсорч, энх цагийн манаа, төрийн болон цэргийн ёслол хүндэтгэлийн үүргээ мадаггүй гүйцэтгэсэн та бүгдээр бид бахархаж байна. Сурлага, сахилгаараа үлгэр жишээ байж, эх орондоо өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэсэн эрхэм дайчдаараа аав ээж, ахан дүүс, нутгийн зон олон нь бахархаж, хүндэтгэлтэйгээр угтан авна гэдэгт эргэлзэхгүй байна. Эрхэм дайчдыг маань Төрийн ёслолын цэргийн цагаан туг өнө мөнхөд ивээж байх болтугай” гэсэн юм. Мөн хурандаа Д.Дугаррагчаа “Эрхэм байлдагч, түрүүч нартаа юуны өмнө баяр хүргэе. Та бүхэн эх орон, тусгаар тогтнол ямар

их үнэ цэнтэй, цэргийн алба гэдэг ямар сайхан орчин бэ гэдгийг бие сэтгэлээрээ мэдэрсэн гэдэгт итгэж байна. Аав ээж, ах дүү, гэр бүл, найз нөхөд, хамт олондоо нүүр бардам очих эрхтэй хүмүүс шүү, та нар. Амьдрал дээр нэгэндээ дэмтэй, ойр дотно яваарай гэж дүү нартаа захъя. Цэргийн албанд улирах боломж та бүхний өмнө хэзээд нээлттэй” гээд хугацаат цэргийн албаа үлгэр жишээ заасан зарим дайчдад шагнал, өргөмжлөл, дурсгалын зүйл гардуулсан юм. Харин халагдаж буй дайчдыг төлөөлж дэд түрүүч С.Мишээлт “Саяхан л бид төрийн торгон цэргүүдийн нэг болж байсан бол өнөөдөр халагдах болчихж. Амьдралын ухаан, цэргийн албаны мөн чанар, сайхныг мэдрүүлсэн нэг жилийг үр бүтээлтэй өнгөрүүлж чадсанаараа бид бахархах

хэрэгтэй. Бидний залгамжийг өвлөн үлдэж байгаа дүү нартаа амжилт хүсье. Дүү нараа бид хэзээ ч мартаггүй. Цэргийн албаа нэр төртэй хаагаарай, Монгол Улсынхаа төлөө зүтгэе” гэсэн нь түүний чин сэтгэлийн үг байлаа. Энэ үеэр нэгэн хүндтэй ёслол болсон нь ЗХЖШ-ын даргын тушаалаар хугацаат цэргийн албанаас ахлагчийн албанд зургаан байлдагч, дэд түрүүч шилжин, цолоо бусад нөхдийнхөө өмнө гардан авсан арга хэмжээ байв. Хурандаа Д.Дугаррагчаа, хурандаа Ж.Мөнхбаяр нар байлдагч А.Чойжилсүрэн, У.Билгүүн, Л.Баасандорж, Г.Мөнхжаргал, Б.Гантогтох, Х.Занданбал нарт дэд ахлагч цолыг гардуулж, ажлын өндөр амжилт хүссэн юм.

Ахлах дэслэгч Д.БОЛОР

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД АНХААРЧ АЖИЛЛАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 256 дугаар анги

Ангийн сургалт, соёл хүмүүжлийн албаны төлөвлөгөөнд туссаны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх, алба хаагчдын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, тэдэнд шинэ мэдлэг мэдээлэл олгох, хамт олны таатай уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор ангийн удирдлага гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдад “Манлайлагчийн ёс зүй”, “Цэргийн

нөхөрлөл насан турш”, “Цэргийн дүрэм бидний харилцаа”, “Хүнтэй ажиллах арга барил” сэдвээр хичээл орлоо.

Үүний зэрэгцээ цэргийн алба хаагчийн нормт хоол, хувцас, цалин, бусад хангалтын талаарх яриа таниулгыг тогтмол явуулж байна. Мөн сарын тэргүүний түрүүч байлдагч нарыг ангийн захирагчийн өрөөтэй танилцуулж, ар гэрт нь талархлын захидлыг тогтмол хүргүүлж байна.

Дэслэгч Э.НОМИН

МОРИН ЦЭРЭГ БОЛОН ЯВГАН ЦЭРГИЙН АЖИЛЛАГААГ ХОСЛУУЛАВ



Зэвсэгт хүчний 232 дугаар анги

2020-2021 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу хээрийн гаралт, полигоны дадлагыг дөрөвдүгээр сарын 5-9-ний өдрүүдэд явууллаа. Хээрийн гаралтын төгсгөлд

онолын мэдлэгийг дадлагаар бататгах хүрээнд ротын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг “Дайсны агаарын десант, хорлон сүйтгэх бүлэгтэй тэмцэх морьт сумангийн ажиллагаа” сэдвээр амжилттай зохион явуулсан юм. Хээрийн сургуульд нэгдүгээр салаа морьтой, хоёр, гуравдугаар

салаа явганаар үүрэг гүйцэтгэсэн бөгөөд нийт бие бүрэлдэхүүний цэргийн мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлж, морьт цэрэг болон явган цэргийн ажиллагааг хослуулсан нь үр дүнгээ өгсөн сургууль болж чадсан юм. Энэ нь 1945 оноос хойш анх удаа морин цэргээр байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль явуулсан түүхэн үйл явдал болов.

Ахмад Ц.ОТГОНСҮРЭН

АНГИЙН РОТ /БАТАРЕЙ/, САЛААНЫ ЗАХИРАГЧ НАРЫН ЗӨВЛӨГӨӨН БОЛОВ

Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Зэвсэгт хүчний тухай хууль, Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүдийн “Цэргийн дотоод албаны дүрэм”, ЗХЖШ-ын даргын албан даалгавар, ангийн захирагчийн тушаалын дагуу мотобуудлагын батальон, артиллерийн дивизионы рот (батарея), салааны захирагч нарын “Зөв төлөвшил-Зөв хүмүүжил” сэдэвт зөвлөгөөнийг амжилттай явууллаа.

Зөвлөгөөнөөр цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөх, удирдан явуулах, заах арга зүйг сайжруулах, дүрмийн дагуу цэргийн алба хаагчидтай харьцах, өөрийн удирдлагад байгаа захирагчдаа сурган хүмүүжүүлж, эх оронч, үндэсний үзэлтэй зөв иргэн хүн



болгон төлөвшүүлэх нь зэрэг сэдвийг онцлов. Зөвлөгөөнийг нээж ангийн захирагч хурандаа Н.Цэцэнхүү рот /батарея/, салааны захирагч нарт хандаж хэлсэн үгэндээ ажил хөдөлмөрийн өндөр амжилт гарган үргэлж манлайлагч нь болж ажиллаж хөдөлмөрлөж явахыг

уриалсан юм. Сургалтыг ангийн захирагчийн тушаалаар томилогдсон бүрэлдэхүүн, мөн Дорнод аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан нар халдвар хамгааллын дэглэмийг баримтлан “Zoom” програм ашиглан цахимаар явууллаа.